

Гадаад иргэдийн ангилал

Гадаад иргэдийн ангилалыг Боловсролын Акт ба Боловсрол Спорт Залуусын Яам (MEYS) тодорхойлно. Гадаад иргэдийн хүүхдүүдийн “Чех хэл ба чех уран зохиол” хичээлийг дүгнэхдээ чех хэлийн мэдлэгийн түвшинг тооцдог.

Чех улсын иргэн бус ба Чех улсад ерөнхий боловсролын сургуульд явдаг хүүхдийн боловсролын дүнг гаргахад Боловсролын Актын 51-р Хэсгээс 53-р Хэсгүүдийг ба бага сургуулийн 48/2005 дугаарын Тогтоолын 14-өөс 17-р Хэсгүүдийг болон сургуулийн явцын зарим нэг шаардлагуудыг тооцож гаргадаг.

Сурагчдыг дүгнэхдээ Чех хэлийн мэдлэгийн түвшин нь хүүхдийн ур чадварыг хамрах Тогтоолын 15(2) ба (4) Хэсгүүдтэй зөвшилцсөн байх шаардлагатай гэж тооцдог. Энэ хүүхдүүдийн “Чех хэл ба чех уран зохиол” хичээлийн агуулгыг дүгнэхдээ Ерөнхий Боловсролын Боловсролын Хөтөлбөрийн Хүрээнд заасны дагуу (эсвэл “Чех хэл ба чех уран зохиол” хичээлийн агуулга), Чех улсын сургуульд явдаг бол чех хэлний мэдлэгийн хүрээ гурван хичээлийн дараалсан хагас жилийн эцэст байнга хүүхдийн ур чадварыг 15(2) Хэсэг ба (4) Тогтоолын дагуу үнэлэх ёстой гэж заасан байна.

Анхны хичээлийн хагас жилийн эцэст гадаад иргэний хүүхдийг орлосон огноонд ч мөн адил сургуулийн тайлагналд дүгнэхгүй. Гэхдээ, хэрвээ сурагч хоёрдугаар хагс жилийн эцэст дүгнэгдээгүй бол тэр тус жилээ дахин давтаж суралцах шаардлагатай.

Словак улсын иргэд хичээлдээ словак хэлд суралцах эрх бүхий, үүнд “Чех хэл ба чех уран зохиол” хамрахгүй.

Хэлний дэмжлэг (Сургуулийн Дүрмийн 16-р Хэсэгтэй зөвшилцөв)

Сургуульд шинээр элсэж байгаа гадаад иргэдийн хүүхдүүд хэлийг төлбөргүй чөлөөтэй суралцах эрхтэй. Гэхдээ Чех улсад маш удаан хугацаагаар амьдарсан хүүхдүүдийн тухайд яах вэ, чех хэлээр тэд чөлөөтэй ярьдаг ч гэсэн чех хэлний хичээл буюу өөр хичээлүүдэд тэдний эзэмшсэн хэлний түвшин хүрэлцэхгүй бол яах вэ? Ямар тусламж дэмжлэг байдаг вэ? 20-р Хэсгийн дагуу хэлний сургалтыг зохицуулахад хүндрэлтэй хүүхдүүдтэй яаж ажиллах вэ (хэрэв тэд сургуульдаа зөвхөн ганцаараа ийм асуудалтай байгаа тохиолдолд)?

Хэлний мэдлэгийн түвшин бага ба доогуур хүүхдүүдийг Боловсролын Актын нэмэлт өөрчлөлт ба Дасан Зохицох Дүрмийн (тусгай хэрэгцээтэй ба хэт авьяаслаг хүүхдүүдийн боловсролын тухай 27/2016 Тогтоол дагуу тусгай хэрэгцээтэй хүүхдүүд (SEN) гэж тооцно.

Дэмжлэг тусламжийн шинэ таван түвшинтэй тогтолцоо, **Чех хэл хоёр дахь хэл (CSL)** чиглэлтэй хүүхдүүдийн хэлний дэмжлэг нь голцуу **хоёрдугаар ба гуравдугаар түвшингийн арга хэмжээ авахыг** шаарддаг. Хоёр тохиолдолд хоёуланд нь сургуулийн зөвлөлийн байгууламжаас (SCF) зөвлөгөө авах хэрэгтэй. Ийм учраас эцэг эх нарт SCF шалгалт өгөх хүсэлт гаргаж, **тэдэнд мэдэгдэж**, тэднээс зохих тусламж дэмжлэгийн **зөвшөөрөл** авч ажиллах хэрэгтэй.

Дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдсан сурагч нар ямар эрхтэй вэ (SMs)?

- a) 2-р түвшин дэмжлэг нь суралцахад нь хэлний мэдлэг дутуу сурагчдыг хамарна (чех хэлний ойролцоо мэдлэг B1-B2).

Зөвлөж байгаа дэмжлэгийн арга хэмжээ:

- Тусгай номуудаар хангах ба туслах материалууд өгөх (гадаад иргэдэд зориулсан чех хэлний гарын авлага);
- Долоо хоногт нэг удаа **сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд** оролцох (сурагчидтай ажиллах эсвэл сургуульдаа ангидаа) – жишээ нь, чех хэл хоёр дахь хэл гэж тодорхойлсон;
- Сургуулийн **тусгай сурган хүмүүжүүлэгчээр заалгах** долоо хоногт нэг цагийн тусгай сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа.

Бага ба дунд сургуулийн CSL-тай сурагчдад **заавал оролцох хичээлийн дээд хэмжээний тооны цагийн хүрээнд** (амьдрал ба зан заншилын огт өөр аж байдалтай учраас дэмжлэг авах хэрэгцээтэй хүүхдүүд) чех хэлийн мэдлэгийг сайжруулах эсвэл чех хэлийг хоёр дахь хэлээ болгож суралцах нь зайлшгүй юм. Сурагчид **120 цаг/жилд хэтрэхгүй CSL/долоо хоногт 3 удаа суралцах эрхтэй.**

- b) 3-р түвшинд орох арга хэмжээ нь **суралцахад хэлний ямар ч мэдлэггүй** сурагчдад зориулсан (A0–A2 чех хэлний мэдлэгийн ойролцоох түвшин).

Зөвлөж байгаа дэмжлэгийн арга хэмжээ:

- Боловсрол сурлагын агуулгыг тохируулах,
- Тусгай номуудаар хангах ба туслах материалууд өгөх (гадаад иргэдэд зориулсан чех хэлний гарын авлага);
- Долоо хоногт 3 цагийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа хийх (үүнд ангид долоо хоногт 1 цагийн хичээл орно) – жишээ нь CSL дэмжлэг;
- Сургуульд тусгай багшаар заалгах долоо хоногт 3 цагийн тусгай сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа хийх, эсвэл, боломжтой үед, сэтгэл зүйчийн туслалцаа авах;
- Өөр нэгэн багшаар 0.5 FTE –ийн хязгаарлагдмал сургалт явуулах (жишээ нь, энэ бол чех хэл хоёр дахь хэлний мэргэжлийн багшийн хичээл байж болно). Бага ба дунд сургуулийн CSL-тай сурагч нарт (CSL –ийн хичээлийг илүү ихээр сурах шаардлагатай сурагч нар), **CSL долоо хоногт 3 цаг байхад болдог, гэхдээ жилд 200 цагаас хэтрэхгүй байх.**
- 3-р дэмжих арга хэмжээний хүрээнд, **маш уртгасан сургалт** шаардах сурагч нарт зөвлөгөө авах байгууллага хэрэгцээтэй байж болно - 27/2016 дугаарын Тогтоолыг харна уу “*Хэрэв тусгай сургалт нэн их шаардлагатай бол (ялангуяа зан заншилын огт өөр орчинд хүмүүжиж байгаа сурагч нарт эсвэл амьжиргааны огт өөр нөхцөлд байдаг сурагч нарт) хэрэв хэрэгцээ гарвал, анхдагч, хоёрдогч ба гуравдагч сургалтыг нэг жилээр уртсгаж болно.*”

Энэ нь Чех улсад ирсний дараа 9-р хичээлийн жилд орох, гэхдээ хэлний мэдлэг дутмаг эсвэл мэдлэг дутмаг шалтгаанаар амжилтгүй сурагч нарт хамаарна. Бид

энэ насны сурагч нарыг дунд сургуулийн орох шалгалтыг өгч, **доорх жил рүү** шилжихийг зөвлөдөг.

CSL–тэй 4-р ба 5-р түвшингийн дэмжих арга хэмжээг зөвхөн тахир дутуу байдал хавсарсан сурагч нарт зөвлөдөг.

Бага сургууль

Боловсролын Акт нь бүх хүмүүст боловсрол эзэмших эрх олгодог; сургууль нь үүний улмаас Чех улсын нутаг дэвсгэрт суугаа гадаадын иргэдэд Чех улсын иргэдэд адил өөрсдийн хууль зүйн эрх байдлыг нотлохгүйгээр бага сургуулийн боловсрол эзэмших эрх олгох шаардлагатай.

Гадаадын иргэд нь бага сургуульд үнэ төлбөргүй суралцах эрх, сургуулийн гуанзанд хооллох эрхтэй бөгөөд сургуулийн байгууламжид өөрийн сонирхлын дагуу боловсрол эзэмших эрхтэй. Сургууль нь шаардлагын дагуу CSL хэрэгцээтэй сурагчдыг хүлээн авах ёстой. CSL-тай сурагчдыг хүлээн авахгүй байх ганцхан шалтгаан бол сургуулийн нөөц хүн хүлээн авах чадвар дутууд оршино. Бид энэ хүүхдүүдийг хүлээн авах нөхцлүүдийг өөрчилсөн сургуулиудад тохиолдсон тохиолдлуудыг хадгалдаг. Боловсролын Актыг зөрчиж байгаа гэдгийг бас санах хэрэгтэй.

48/2005 дугаарын Тогтоолын (10-р хэсэг) дагуу сургуулийн тэргүүлэх багшаас сурагчийн хууль ёсны төлөөлөгчид хүүхдийг сургуульд орсноос долоо хоногийн хугацааны хүрээнд хэлний хичээлд суралцах боломжийн тухай мэдээлэхийг шаарддаг. Сургууль нь ийм хүүхдүүдийг зохих ангид оруулдаг. Үүний тухай илүү мэдээлэл авахын тулд Чех улсад үнэ төлбөргүй хэлний хичээл заадаг сургуулуудын жагсаалтыг Боловсролын Актын 20-р Хэсгийн дагуу хэлний бэлтгэл зэргийг харна уу.

CSL-тэй сурагчдын дэмжлэг нь 561/2004 дугаарын Боловсролын Актын нэмэлт өөрчлөлт ба 27/2016 дугаарын Тогтоолд хамаарсан бүх хүүхдүүдэд ба сурагч нарт ангид нь дэмжлэг зохион байгуулахыг шаарддаг. Энэ нь **CSL-тэй хүүхдүүд ба сурагч нарыг хамаарна.**

Сургуульд дасан зохицох ба эх хэлийг заахад олгох төлбөргүй тусламж

Мужийн хэсгийн эрх мэдэлтэй захиргаа нь сурагчийн оршин суух хаягийн дагуу, сургуулийн үүсгэн байгуулагчтай хамтран ажилласны улмаас доорхийг батлана:

(a) ерөнхий боловсролын сургуульд ороход үнэ төлбөргүй бэлдэх, сурагчдын хэрэгцээнд тохируулсан хэлний хичээл заах,

(b) сурагчийн эх нутагтай хамт ажиллангаа сурагчийн эх хэл ба улсынх нь соёл заншлыг зааж сургахыг дэмжих, үүнийг бага сургуулийн хичээлийн хуваарьтай хамтран зохицуулж тогтмол сургах ёстой.

Энэ хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэхэд багш нарын боловсролыг харгалзаж, орон нутгийн захиргаа үйл ажиллагаанд тэдний бэлтгэлийг хангаж өгөх үүрэгтэй. Орогнол цагаачлал хүсэгчдийн байгууламжид амьдрах цагаачлал хүсэгчдийн хүүхдүүд суралцдаг

бага сургуулиуд ба цагаачлалын байгууламжаас гадуур амьдардаг хүүхдүүд мөн адил хэлний үндсэн сургалтанд хамрана.

Гадаад сурагч нар ба хүүхдүүдийг сургах хууль зүйн хүрээ

Үндсэн эрх бүгдэд нөлөөлнө, үүнд тухайн хүний хүйс, арьсны өнгө, хэл, шашин итгэл, улс төрийн эсвэл өөр нэгэн үзэл бодол, нийгмийн эсвэл үндэсний гарал үүсэл, үндэсний эсвэл омгийн цөөнх хэсэг, өмч хөрөнгө, хүйс эсвэл байдлаас огт хамаарахгүй. Тэд бүгд иргэдэд үйлчилнэ, гадаад иргэдэд ч мөн адил үйлчилдэг. Үндсэн эрхийг одоогийн хүчин төгөлдөр хуулиар илэрхийлсэн.

Хууль зүйн хамрах хүрээ доорх хэсгүүдээс бүрдэнэ:

- Чех Улсын Үндсэн Хуулийн 10-р Зүйлийн олон улсын конвенцууд (Хүний Эрх Хамгаалах Конвенц ба Суурин Эрх Чөлөө, Хүүхдийн Эрхийн Конвенц, Цагаачлал Орогногчдын тухай Конвенц гэх мэт)
- Суурийн Эрх ба Эрх Чөлөөний Батламж – Европын Хууль Зүй (дүрмүүд ба удирдамжууд)
- Гадаад иргэдийн байнга оршин суух
- Цагаачлал Орогнолын Акт
- Түр Зуурын Хамгааллын Акт
- Боловсролын Акт – үүнд хамаатай актууд, тогтоолууд, яамнаас гаргасан гарын авлагууд.

Гадаадын иргэдийн байнга оршин суух хаягийг хамрах тусгай эрх ба үүргийн тухай доорх хуулиудаас уншиж сонирхож болно:

- Цагаачлал хүсэх Акт
- Түр Зуурын хамгааллын Акт
- Гадаад Иргэдийн Оршин Суух Акт